

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хангах, гэр бүлийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, хүүхэд, эх, эцэгт мөнгөн дэмжлэг үзүүлэх, гэр бүлийн хөгжлийг дэмжих тогтолцоо, байгууллагын чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Гэр бүлийг дэмжих тухай хууль тогтоомж

2.1.Гэр бүлийг дэмжих тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуульд заасан шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын харьяат иргэн, түүний гэр бүл, Монгол Улсад хууль ёсоор оршин сууж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, түүний гэр бүл энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“гэр бүл” гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.2-т заасныг;

4.1.2.“асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж Гэр бүлийн тухай хуулийн 63.1, 64.1-д заасан хүний хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр мөн хуулийн 67.1.1-д заасны дагуу тогтоогдсон хүнийг;

4.1.3.“хүүхэд үрчлэн авах” гэж Гэр бүлийн тухай хуулийн 55, 57, 58 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд үрчлэн авахыг;

4.1.4.“хүүхдээ асарч байгаа” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 139.1-д заасан хүүхэд асрах чөлөөтэй болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

тухай хуулийн 3.1.3-т заасан ажилгүй эх, эцэг 0-2 хүртэлх насны хүүхдээ асарч байгааг;

4.1.5."гэр бүлийн үйлчилгээний мэдээллийн цахим систем" гэж иргэд, гэр бүлд төрөөс үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний мэдээлэл, үйлчилгээг шуурхай хүргэх, дэмжлэг, үйлчилгээ авах үйл явцыг хялбаршуулах, үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах, иргэдийн өөрсдөө суралцах боломжийг бүрдүүлэх зорилго бүхий аюулгүй, нэгдсэн үндэсний цахим платформыг;

4.1.6. "гэр бүлийн цахим нэгж" гэж энэ хуулийн 4.1.5-д заасан системд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.4-д заасан иргэний улсын бүртгэлийн дагуу танигдсан хэрэглэгчийн гэр бүлийн нэгжийг;

4.1.7."цахим зөвшөөрөл" гэж энэ хуулийн 4.1.5-д заасан системд нэвтрэхэд хэрэглэгчээс тухайн хүний гэр бүл, гэр бүлийн бусад гишүүнтэй холбоотой мэдээлэл авахад зөвшөөрөл авахыг.

5 дугаар зүйл. Гэр бүлийн хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим

5.1.Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах;

5.1.2.жендэрийн эрх тэгш байдлыг хангах,

5.1.3.гэр бүл, түүний гишүүдийг ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.4.үндэсний өв соёл, уламжлал, ёс заншил, гэр бүлийн үнэт зүйлийг хүндэтгэх;

5.1.5.иргэний үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх журамт үүргийг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.1.6.хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг хадгалах;

5.1.7.гэр бүл, олон нийтийн оролцоог дэмжих;

5.1.8.орон нутаг, хувийн хэвшлийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх;

5.1.9. үйлчилгээг үл тулгах, сонголттой байлгах, сайн дурын үндсэн дээр хамруулах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6 дугаар зүйл. Гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэл

6.1.Гэр бүлийн хөгжлийг төрөөс дараах чиглэлээр дэмжинэ:

6.1.1.орон сууцны дэмжлэг үзүүлэх;

6.1.2.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх;

6.1.3.ажил, амьдралын тэнцвэрийг хангах;

6.1.4.гэр бүлийн боловсролыг дэмжих;

- 6.1.5.эрүүл мэндийг дэмжих;
- 6.1.6.нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх;
- 6.1.7.гэр бүлийн өдрийг тэмдэглэх.

7 дугаар зүйл. Орон сууцны дэмжлэг үзүүлэх

7.1.Төрөөс гэр бүлийг орон сууцтай болоход хөнгөлөлттэй, урт хугацааны ипотекийн зээл олгох, ипотекийн зээлийн урьдчилгаа, барьцаа хөрөнгөгүй гэр бүлд дэмжлэг үзүүлэх асуудлыг Үндэсний баялгийн сангийн тухай хууль, татварын, холбогдох бусад хууль тогтоомжид тусгаж шийдвэрлэнэ.

7.2.Гэр бүлд орон сууцны дараах дэмжлэгийг үзүүлнэ:

7.2.1.залуу гэр бүл, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл анх удаа орон сууц худалдан авах тохиолдолд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.1.2-д заасан Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгөөр төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрт эхний ээлжид хамруулах;

7.2.2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4.1.6-д заасан хуримтлалын нэрийн дансны хөрөнгөөр орон сууцны төлбөрийн 5 хувийг бүрдүүлсэн тохиолдолд урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргах;

7.2.3.энэ хуулийн 7.2.1-т заасан хөтөлбөрт хамрагдах боломжгүй 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлийг эхний ээлжид түрээсийн орон сууцанд хамруулах.

7.3.Иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилж авсан, эсхүл эзэмших эрхийн гэрчилгээтэй газар дээрээ эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барихад дэмжлэг үзүүлэх асуудлыг орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага тухайн орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

7.4.Энэ хуулийн 7.2-т заасан дэмжлэгт хамрагдах гэр бүлийн шалгуур, нөхцөлийг гэр бүлийн хөгжлийн болон орон сууц, барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

8 дугаар зүйл. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх

8.1.Гэр бүлд албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг татварын тухай хууль тогтоомжоор шийдвэрлэнэ.

8.2.Гэр бүлийн хүүхдийн тооноос хамааруулан гэр бүлийн дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:

8.2.1.3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийн эхнэр, нөхрийн аль нэгний цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

8.2.2.4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл орон сууцны нөхцөлөө сайжруулах зорилгоор анхны орон сууцаа борлуулснаас олсон орлого;

8.2.3.эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор байгальд ээлтэй эко жорлон худалдан авсан нь баримтаар нотлогдож байгаа бол уг зардалтай тэнцэх тухайн жилийн орлого.

9 дүгээр зүйл. Ажил, амьдралын тэнцвэрийг хангах

9.1.Ажил олгогч нь хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид заасан ажилтны хөдөлмөр эрхлэлтэд уян хатан нөхцөл хэрэглэх, ажил, амьдралын тэнцвэрийг хангахад чиглэсэн дараах арга хэмжээг ажилтны төлөөлөлтэй зөвшилцөн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээндээ тусган хэрэгжүүлж болно:

9.1.1.сургуулийн өмнөх болон бага боловсролд хамрагдаж байгаа хүүхэдтэй ажилтны хүсэлтээр хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэг, сургуульд хүүхдээ хүргэж өгөх, авахад нь зориулж, ажилтны цалин хөлсийг нь бууруулахгүйгээр ажлын цагийг 2 хүртэлх цагаар богиносгох;

9.1.2.гэр бүлийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа ажилтанд долоо хоногийн 1 өдөр гэрээсээ, эсхүл зайнаас ажиллах боломжоор жилд нэг удаа 3 хүртэлх сарын хугацаанд хангах;

9.1.3.ерөнхий боловсролын сургуульд суралцдаг хүүхэдтэй ажилтан хичээлийн жилийн өвлийн амралтын хугацаанд ээлжийн амралтаа эдлэхийг хүсвэл түүний ээлжийн нэмэгдэл амралтын хугацааг ажлын 2 өдрөөр нэмэгдүүлэн олгох;

9.1.4.ажилтны тоо, санал, хүсэлтийг үндэслэн байгууллагын цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээ ажиллуулах, хүүхдийн насны онцлогт тохирсон хүүхдийн өрөө бий болгох;

9.2.Ажил олгогч нь ажилтны эрүүл мэндийг дэмжих, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл. Гэр бүлийн боловсролыг дэмжих

10.1.Иргэд, олон нийт, гэр бүлийн гишүүдэд гэр бүлийн боловсролыг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг дараах чиглэлээр үзүүлнэ:

- 10.1.1.гэр бүлийн эрх зүй, гэрлэлт, гэрлэгчдийн үүрэг, хариуцлага;
- 10.1.2.гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд;
- 10.1.3.гэр бүлийн үнэт зүйл, угийн бичиг хөтлөлт;
- 10.1.4.гэр бүлийн харилцаа, ёс зүй;
- 10.1.5.хүүхдийн хүмүүжил, хөгжил;
- 10.1.6.гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх;
- 10.1.7.гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд;
- 10.1.8.гэр бүлийн төсөв, санхүү.

10.2.Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг аймаг, дүүргийн боловсролын болон гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

10.3.Энэ хуулийн 10.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэх аргачлал, зардлын нормативыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, зардлыг Засгийн газрын гишүүний төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

11 дүгээр зүйл. Эрүүл мэндийг дэмжих

11.1.Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

11.1.1.гэр бүлээрээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авч болох гэр бүлийн эрүүл мэндийн үйлчилгээ нэвтрүүлэх;

11.1.2.өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээг тогтмол хугацаанд, чанартай үзүүлэх;

11.1.3.бага насны хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүлд эрүүл мэндийн нэмэлт тусламж, үйлчилгээг үзүүлэх;

11.1.4.сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай гэр бүлийн гишүүнд сэтгэлзүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ үзүүлэх;

11.1.5.согтуурах, мансуурах донтой болон дэлгэцэд донтох өвчтэй гэр бүлийн гишүүнд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх.

11.2.Энэ хуулийн 11.1.1-д заасан үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5-д заасан үйл ажиллагааг аймаг, дүүрэг, сумын эрүүл мэндийн холбогдох байгууллага тус тус хэрэгжүүлнэ.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэх аргачлал, зардлын нормативыг эрүүл асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, зардлыг Засгийн газрын гишүүний төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

12 дугаар зүйл. Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх

12.1.Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн тодорхойлж, дараах чиглэлээр үзүүлнэ:

12.1.1.гэрлэгчдийн харилцааг сайжруулах, гэрлэлт цуцлалтаас урьдчилан сэргийлэх талаар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;

12.1.2.гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлахад эвлэрүүлэн зуучлагчийн хүсэлтээр эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

12.1.3.эх, эцэгт хүүхэд хүмүүжлийн эерэг аргын ур чадвар олгох сургалт зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх;

12.1.4.эх, эцгээсээ тусдаа төрөл, садны хүнтэйгээ амьдарч байгаа хүүхдэд шаардлагатай бол нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх;

12.1.5.гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээ, хамгааллын үйлчилгээ үзүүлэх;

12.1.6.гэр бүлийн гишүүдийг тэдний хэрэгцээ, шаардлагыг үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн, нийгмийн халамжийн зэрэг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасан үйлчилгээг нийгмийн ажлын үйлчилгээний стандартын дагуу аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

12.3.Энэ хуулийн 12.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэх аргачлал, зардлын нормативыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, зардлыг Засгийн газрын гишүүний төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

13 дугаар зүйл. Гэр бүлийн өдрийг тэмдэглэх

13.1.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасан Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдөр, 4.1.2-т заасан Цагаан сарын баярын өдөр долоо хоногийн амралтын өдөр тохиовол дараагийн ажлын өдөрт шилжүүлж, нийтээр амарна.

13.2.Эрүүл, тогтвортой гэр бүлийг төлөвшүүлэхэд хувь хүн, гэр бүл, нийгэм нийтээрээ идэвхтэй оролцох, гэр бүлд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.5-д заасан “Гэр бүлийн өдөр” тохиосон долоо хоногийг нийтээр тэмдэглэнэ.

13.3.Энэ хуулийн 13.2-д заасан гэр бүлийн өдрийн хүрээнд аймаг, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны боловсролын, соёлын болон гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагатай хамтран зохион байгуулж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

13.3.1.олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах;

13.3.2.угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх;

13.3.3.25 ба түүнээс дээш жил хамт амьдарсан, үр хүүхдээ зөв өсгөж хүмүүжүүлсэн гэр бүлийг урамшуулах, алдаршуулах;

13.3.4.аж ахуйн нэгж, байгууллага сайн дурын үндсэн дээр гэр бүлд зориулан бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ үнэ, тарифт хөнгөлөлт, тусламж үзүүлэхийг дэмжих;

13.3.5.орон нутгийн онцлогт нийцсэн бусад арга хэмжээ хэрэгжүүлэх.

13.4.Энэ хуулийн 13.3-т заасан үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тухайн орон нутаг санхүүжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД, ЭХ, ЭЦЭГТ ОЛГОХ МӨНГӨН ДЭМЖЛЭГ

14 дүгээр зүйл. Хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг

14.1.Хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг /цаашид “мөнгөн дэмжлэг” гэх/ дараах төрөлтэй байна:

- 14.1.1.хүүхдийн мөнгөн дэмжлэг;
- 14.1.2.жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг;
- 14.1.3.хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг;
- 14.1.4.ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг;
- 14.1.5.олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн дэмжлэг.

14.2.Энэ хуулийн 14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан мөнгөн дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтооно.

14.3.Мөнгөн дэмжлэгийн хэмжээг шинэчлэн тогтооход инфляцын түвшинг харгалзан үзнэ.

14.4.Мөнгөн дэмжлэгт 4 жил тутамд үнэлгээ хийж өөрчлөн шинэчлэх, зогсоох, нэгтгэх талаар гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.

14.5.Энэ хуулийн 14.1.5-д заасан мөнгөн дэмжлэг олгох харилцааг Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулиар зохицуулна.

14.6.Энэ хуулийн 14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан мөнгөн дэмжлэгт шаардагдах зардлыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

15 дугаар зүйл. Хүүхдийн мөнгөн дэмжлэг

15.1.Хүүхдийн мөнгөн дэмжлэгийг Монгол Улсын харьяат хүүхдэд төрснөөс хойш 18 нас хүртэлх хугацаанд сар бүр олгоно.

15.2.Төрөлжсөн асрамжийн газарт амьдарч байгаа 14 хүртэлх насны хүүхдэд тухайн асрамжийн газар нь хадгаламжийн данс нээлгэж, хүүхдийн мөнгөн дэмжлэгийг банканд бүрэн хадгалуулна. Харин 14 ба түүнээс дээш насны хүүхдийн дэмжлэгийн 80 хувийг банканд хадгалуулж, 20 хувийг хүүхэд өөрөө захиран зарцуулах зориулалт бүхий харилцах дансыг нээлгэх бөгөөд энэ данс нь цахим карттай байна.

15.3.Асрамжийн газар амьдарч байгаа хүүхдийн хадгаламжийн дэвтрийг тухайн асрамжийн газар байрлах аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага хадгалж, хүүхдийг 16 нас хүрсний дараа өөрт нь өгнө.

15.4.Цагдан хоригдож байгаа, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа хүүхдийн нэр дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа газар, хэлтэс банканд хадгаламжийн данс нээлгэж, хүүхдийн хадгаламжийн дэвтрийг тухайн хорих анги байрлах аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан асуудал хариуцсан байгууллага хадгалж, хүүхдийг суллагдсаны дараа өөрт нь хүлээлгэн өгнө.

15.5.Хүүхэд нас барсан тохиолдолд хадгаламжийн дэвтрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өв залгамжлагчид, хууль ёсны өв залгамжлагч байхгүй тохиолдолд Хүүхдийн төлөө санд хүлээлгэн өгнө.

16 дугаар зүйл. Жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг

16.1.Жирэмсний таван сартайгаас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэлх хугацаанд эхэд сар бүр мөнгөн дэмжлэг олгоно.

16.2.Эх хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг авч байх хугацаандаа жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг авах эрх үүсвэл түүнд уг дэмжлэгийг давхар олгоно.

17 дугаар зүйл. Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг

17.1.Төрүүлсэн болон үрчилж авсан 0-2 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэгт асарч байгаа хүүхдийн тооноос үл хамааран 24 сарын хугацаанд хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг олгоно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан мөнгөн дэмжлэгийг эх, эцэг өөрөө хүсвэл дараах сонголтоор авч болно:

17.2.1.24 сарын хугацаанд сар бүр;

17.2.2.12 сарын хугацаанд сар бүр, ингэхдээ 24 сарын хугацаанд ногдох мөнгөн дэмжлэгийг хувааж сар бүр;

17.2.3.12 сарын хугацаанд авах, ингэхдээ нэг жилд олгогдох хэмжээний мөнгөн дэмжлэгийг төрсний дараа нэг удаа, үлдсэнийг 12 сарын хугацаанд сар бүр.

17.3.Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийг авч байсан эх, эцгийн аль нэг хүүхдээ 2 нас хүрэхээс өмнө ажилд орсон тохиолдолд мөнгөн дэмжлэгийг хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэгт олгоно.

17.4.Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийг Нийгмийн даатгалын сангаас олгох дэмжлэгийн тухай хуульд заасны дагуу олгох жирэмсний болон амаржсаны мөнгөн дэмжлэгтэй давхардуулан олгохгүй.

17.5.Энэ зүйл нь холбогдох хуульд заасны дагуу 0-2 хүртэлх насны хүүхдийн асран хамгаалагчаар тогтоогдсон этгээдэд нэгэн адил үйлчилнэ.

17.6.Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг авч байсан эх, эсхүл эцэг ажилд орсон үндэслэлээр мөнгөн дэмжлэг нь зогссоны дараа хүүхдээ асрах шаардлагын улмаас ажлаасаа гарсан, урт хугацааны чөлөө авсан тохиолдолд хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийг үргэлжлүүлэн авах эрхтэй.

18 дугаар зүйл. Ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг

18.1.Ихэр хүүхдэд нэг удаа мөнгөн дэмжлэг олгох бөгөөд мөнгөн дэмжлэг авах эрх хүүхэд төрснөөс хойш 4 нас хүртэл хүчинтэй байна.

18.2.Ихэр хүүхдэд олгох мөнгөн дэмжлэгийн хэмжээг хүүхэд тус бүрт олгоно.

18.3.3 болон түүнээс дээш ихэр хүүхдэд олгох мөнгөн дэмжлэгийн хэмжээг 2 ихэр хүүхдэд олгох хэмжээнээс өөрөөр тогтоож болно.

18.4.Ихэр хүүхдийн төрсөн эх, эцэг ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэгийг аваагүй бол хүүхэд үрчлэгдсэн, эсхүл асран хамгаалагч тогтоогдсон тохиолдолд үрчлэн авсан эх, эцэг, асран хамгаалагчид олгоно.

19 дүгээр зүйл. Мөнгөн дэмжлэг олгох

19.1.Мөнгөн дэмжлэг олгохтой холбоотой үйл ажиллагааг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн зохион байгуулна.

19.2.Мөнгөн дэмжлэгийг авахыг хүссэн иргэн хүсэлтээ сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэнд биечлэн эсхүл цахимаар гаргана. Мөнгөн дэмжлэг авах хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх журмыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.3.Мөнгөн дэмжлэгийг иргэний хүсэлт гаргасан өдрөөс эхлэн хуулиар тогтоосон бусад эрх нь дуусгавар болсон өдрийг хүртэл хугацаанд, нас барсан тохиолдолд нас барсан сарыг дуусах хүртэл хугацаанд түүний сонгосон арилжааны банк дахь дансаар дамжуулан олгоно.

19.4.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас иргэнд 1 жилээс доош хугацааны олгогдоогүй мөнгөн дэмжлэгийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын шийдвэрийг, 1 жилээс дээш хугацааны мөнгөн дэмжлэгийг шүүхийн шийдвэрийг үндэслэн нөхөн олгоно.

20 дугаар зүйл. Мөнгөн дэмжлэг олгохыг түдгэлзүүлэх

20.1.Хүүхдийн мөнгөн дэмжлэгийг эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгохыг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ:

20.1.1.эх, эцэг нь сураггүй алга болсон бөгөөд цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжилж байгаа;

20.1.2.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.1-д заасан үндэслэлээр хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан;

20.1.3.эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, хүүхдийн эрхийг зөрчсөн талаар хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт гарсан;

20.1.4.эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон.

20.2.Хүүхдийн мөнгөн дэмжлэг олгохыг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан талаар хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт, эсхүл шүүхийн шийдвэрийг үндэслэн түдгэлзүүлсэн хугацаанаас хойш тооцож үргэлжлүүлэн олгоно.

21 дүгээр зүйл. Мөнгөн дэмжлэг олгохыг зогсоох

21.1.Хүүхдийн мөнгөн дэмжлэгийг дараах үндэслэлээр зогсооно:

21.1.1.хүүхэд 18 насанд хүрсэн дараагийн сараас;

21.1.2.хүүхэд Монгол Улсын харьяатаас гарсан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсан өдрөөс;

21.1.3.хүүхэд нас барсан бол дараагийн сараас;

21.1.4.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэний хүүхэд, харьяалалгүй хүүхэд Монгол Улсаас бүрмөсөн буцах хүсэлт гаргасан бол Монгол Улсын хилээр гарсны дараа сараас;

21.1.5.хуурамч баримт бичиг бүрдүүлж мөнгөн дэмжлэг авсан бол шүүхийн шийдвэр, эсхүл улсын байцаагчийн шийдвэрт заасан хугацаанаас.

21.2.Жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг, хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийн олголтыг дараах үндэслэлээр зогсооно.

21.2.1.жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг авах хугацаа дууссан дараагийн сараас;

21.2.2.0-2 хүртэлх насны хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийг хүүхэд нь 2 нас хүрсэн, үрчлүүлсэн, нас барсан,

21.2.3.эх, эцэг, асран хамгаалагчийн Хөдөлмөрийн тухай хуулийн 139.1-д заасан хүүхэд асрах чөлөөний хугацаа дууссан бол дараагийн сараас;

21.2.4.Монгол Улсын харьяатаас гарсан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсан өдрөөс;

21.2.5.Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь Монгол Улсаас бүрмөсөн буцах хүсэлт гаргасан бол Монгол Улсын хилээр гарсны дараа сараас;

21.2.6.мөнгөн дэмжлэг авч байх хугацаанд эх, эцэгт ажил олгогчийн зүгээс хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгосон нь баримтаар тогтоогдсон;

21.2.7.хуурамч материал бүрдүүлэн мөнгөн дэмжлэг авсан, олгосон нь хяналт шалгалтаар тогтоогдсон.

21.3.Энэхүү хуулийн 21.2.3-д заасны дагуу мөнгөн дэмжлэг олголт нь зогсоогдсон ч тодорхой хугацааны дараа ажилгүй болж хүүхдээ асарч байгаа бол эх, эцэг мөнгөн дэмжлэг авах хүсэлтээ дахин гаргаж болно.

22 дугаар зүйл. Мөнгөн дэмжлэгтэй холбоотой бусад харилцаа

22.1.Хууль бус арга замаар мөнгөн дэмжлэг авсан нь шүүхийн шийдвэр, эсхүл улсын байцаагчийн шийдвэрээр тогтоогдсон бол суутгал хийх, эсхүл шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандаж хохирлыг барагдуулах арга хэмжээ авна.

22.2.Суутгалын хэмжээ нь тухайн иргэний мөнгөн дэмжлэгийн 50 хувиас хэтрэхгүй.

22.3.Энэ хуулийн 22.1-д зааснаас бусад тохиолдолд аливаа иргэн, хуулийн этгээд мөнгөн дэмжлэгээс суутгал хийх, мөнгөн дэмжлэгийг барьцаалах, зээлийн төлбөрт суутгахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

23 дугаар зүйл. Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

23.1.Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

23.1.2.гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

23.1.3.гэр бүлийн хөгжлийг дэмжих, ээлтэй орчныг бий болгох чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангах,

23.1.4.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг батлах;

23.1.5.гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

23.1.6.хуульд заасан бусад чиг үүрэг.

24 дүгээр зүйл. Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

24.1.Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.1.1.гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар гүйцэтгэсэн ажлын үр дүнг Засгийн газар, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өмнө хариуцан тайлагнах;

24.1.2.гэр бүлийн хөгжлийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, статистик тоо мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах;

24.1.3.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг төлөвлөн хэрэгжүүлэх, зарцуулалтад хяналт тавих;

24.1.4.аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

24.1.5.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг холбогдох байгууллага, их, дээд сургуультай хамтран зохион байгуулах;

24.1.6.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий төрийн бус байгууллагыг энэ хуулийн 26.1.4-д заасан журмын дагуу магадлан итгэмжлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

24.1.7.гэр бүлийг эвлэрүүлэн зуучлах эрх бүхий байгууллага, мэргэжилтэнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

24.1.8.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээд, гэр бүл, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих, хамтран ажиллах.

24.1.9.хуульд заасан бусад чиг үүрэг.

25 дугаар зүйл. Аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын чиг үүрэг

25.1.Аймаг, дүүрэг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.1.1.гэр бүлийн талаарх бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биелэлтийг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын өмнө тайлагнах;

25.1.2.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэхээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж ажиллах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, гэрээний биелэлтийг дүгнэх;

25.1.3.гэр бүл угийн бичгээ хөтлөхөд нь мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн соёлын газар, сум, дүүргийн соёлын төвтэй хамтран хэрэгжүүлэх;

25.1.4.Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг удирдлагаар хангах;

25.1.5.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах;

25.1.6.гэр бүлд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавих;

25.1.7.хүн, хуулийн этгээдтэй гэр бүлд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаа, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;

25.1.8.хуульд заасан бусад чиг үүрэг.

26 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан

26.1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нь дор дурдсан гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, үйлчилгээг Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвтэй хамтран төлөвлөн зохион байгуулж, хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээнэ:

26.1.1.энэ хуулийн 10.1-д заасан иргэд, олон нийт, гэр бүлийн гишүүдэд гэр бүлийн боловсролын сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

26.1.2.энэ хуулийн 12.1-д заасан нийгэм, сэтгэл зүй, нийгмийн ажлын үйлчилгээг гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийсний үндсэн дээр тодорхойлж, шаардлагатай иргэн, гэр бүлд үзүүлэх;

26.1.3.гэр бүлийг дэмжих чиглэлээр энэ хуулийн 13.3-т заасан болон бусад холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд сум, хорооны

боловсролын, соёлын, эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагатай хамтран ажиллах;

26.1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

27 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын чиг үүрэг

27.1.Орон нутагт гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.1.1.гэр бүлийг дэмжих бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн гэр бүл, хүн амын бүлгийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх;

27.1.2.аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг, хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт гэр бүлийн хөгжил, сайн сайхан байдлыг хангах үйл ажиллагааг тусгаж, биелэлтэд нь хяналт тавих;

27.1.3.барилга байгууламж, дэд бүтцийг гэр бүлд ээлтэй байдлаар төлөвлөх, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, зам, гудамж, талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулах, орчны аюулгүй байдлыг хангах;

27.1.4.хүсэлтийг харгалзан иргэнд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох, орон байртай болгох, иргэнийг малжуулах, ажлын байртай болгох, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах;

27.1.5.гэр бүлийн боловсрол, соёлыг түгээн дэлгэрүүлэх, гэр бүлийн гишүүдийн оролцоог хангасан, гэр бүлд ээлтэй үйл ажиллагаа зохион байгуулахад иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, санаачилгыг дэмжих;

27.1.6.гэр бүлд ээлтэй орчныг бий болгох, гэр бүлд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулсан хүн, хуулийн этгээдийг орон нутгийн хөгжлийн бодлогын дагуу дэмжих.

27.1.7.хуульд заасан бусад чиг үүрэг.

28 дугаар зүйл. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв

28.1.Аймаг, дүүрэгт гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв /цаашид “төв” гэх/-ийг ажиллуулна.

28.2.Суманд нутаг дэвсгэрийн хүн ам, гэр бүлийн тоо, хүний, санхүү, хүний нөөцийн боломжийг харгалзан төвийг ажиллуулж болно.

28.3.Төвийг орон нутгийн соёл, спорт, хүүхэд, залуучууд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв болон бусад боломжтой

байгууламжийг түшиглэн ажиллуулж, төвийн үйл ажиллагааны урсгал зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

28.4.Төв нь гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, үйлчилгээг иргэн, олон нийтийн санал, санаачилга, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлнэ.

28.5.Төвийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, ажиллах үлгэрчилсэн дүрмийг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

29 дүгээр зүйл. Гэр бүл, хүн ам зүйн судалгаа

29.1.Гэр бүл, хүн амын өсөлтийг дэмжих урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлт, стратегийг тодорхойлох зорилгоор гэр бүлийн суурь судалгааг Үндэсний статистикийн хороо, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран таван жил тутамд хийнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ СИСТЕМ

30 дугаар зүйл. Гэр бүлийн үйлчилгээний мэдээллийн цахим систем

30.1.Гэр бүлийн үйлчилгээний мэдээллийн цахим систем (цаашид “систем” гэх)-ийг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллуулна.

31 дүгээр зүйл. Аюулгүй нэвтрэлт ба гэр бүлийн нэгжийн цахим бүртгэлийн хамгаалалт

31.1.Иргэн системд мэдээллээ таниулан баталгаажуулсны үндсэн дээр аюулгүй нэвтрэнэ.

31.2.Системд танигдсан хэрэглэгчийг гэр бүлийн нэгжийн цахим бүртгэлтэй холбоно.

31.3.Хэрэглэгч өөрийн болон гэр бүлийн гишүүний өмнөөс үйлчилгээг авахаар хүсэлт гаргаж болно.

31.4.Гэр бүлийн гишүүний өмнөөс үйлчилгээ авахад гэр бүлийн нэгжийн бусад гишүүдийн мэдээллийг авах шаардлагатай бол тэдний цахим зөвшөөрлийг авсны дараа хүсэлтийг үргэлжлүүлнэ.

32 дугаар зүйл. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал

32.1.Систем нь мэдээллийн нэгтгэл, боловсруулалт хийхэд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуулийг чанд мөрдөнө.

32.2.Мэдээллийн ашиглалт, хадгалалт, хуваалцах талаарх тодорхой мэдээллийг хэрэглэгчдэд өгнө.

32.3.Системийн үндсэн мэдээллээс гаднах мэдээлэл хуваалцах, үйлдэл хийхэд иргэн, гэр бүлээс цахим зөвшөөрөл авсан байна.

32.4.Хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүй хандах, өөрчлөх, задруулах, устгахаас хамгаалж, техникийн болон зохион байгуулалтын найдвартай аюулгүй байдлыг хангана.

33 дугаар зүйл. Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын системийн талаарх бүрэн эрх

33.1.Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.1.1.нийтэд нээлттэй мэдээллийн порталын контентыг мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллага, шинжээчдийн оролцоотойгоор боловсруулах, батлах, хөтөлж, удирдах;

33.1.2.системээр дамжуулан үзүүлэх үйлчилгээний хүрээ, нөхцөл, хэрэглэгчийн нэвтрэлт, танилт, мэдээлэл солилцох, зөвшөөрөл олгох зэрэг үйл ажиллагааны журам, зааврыг боловсруулж батлах;

33.1.3.системийн үйл ажиллагаанд хувь хүний нууц, мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих

33.1.4.системийн программ хангамж, техникийн дэд бүтцийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, аюулгүй байдлыг техникийн түвшинд хангахсистемийн засвар үйлчилгээ, техникийн дэмжлэгийг үзүүлэх;

33.1.5.системийн программ хангамжийг хөгжүүлэх, шинэчлэх, сайжруулах;

33.1.6.системийн ерөнхий удирдлага, засвар үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах.

33.1.7.гэр бүлд дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх холбогдох төрийн байгууллагын мэдээллийн интеграц, хамтын үйл ажиллагааг хангах үүднээс дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах;

33.1.8.Системийн мэдээлэл хадгалалт, ашиглалт, мэдээлэлд хяналт тавих, түүний аюулгүй байдлыг хангах журмыг цахим хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

34 дүгээр зүйл. Шилжилтийн үеийн зохицуулалт

34.1. Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж авахаар тогтоолгосон эх, эцэг, асран хамгаалагчийн эрх дуусах хүртэл хугацаанд хэвээр олгогдоно.

35 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

35.1. Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

35.2. Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

36 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

36.1. Энэ хуулийг 202...оны ... дүгээр сарын өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ